

2005 ОНД СЭЛЭНГЭ АЙМГИЙН НУТАГТ АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА ХИЙСЭН ТУХАЙ

З.БАТСАЙХАН¹, С.ӨЛЗИЙБАЯР²

¹Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи-Археологийн тэнхим, e-mail: batsaihan@num.edu.mn

²Шинжлэх Ухааны Академи, Түүхийн Хүрээлэн, sulzii70@yahoo.com

Түлхүүр үгс: Карниковын ам, Бургалдайн хөндий, банзан хашлага, хүннү, монгол булш, нумын хос амгавч, ланз хэлбэрийн үсэг, богтаг малгай


Өгүүллийн товч агуулга: Ерөө голын сав Карниковын аман дахь хүннү булш нь хэдийгээр тоногдсон ч банзаар авс бус хашлага хийж оршуулга үйлдэж байсан тухай мэдээг бидэнд өгч байгаа юм. Судлагдсан хүннү булшны оршуулгын зан үйлээс үзэхэд дүнз, шургаагаар хашлага хийдэг болох нь давамгайлж байгаа бол банзаар хашлага хийсэн баримт бидэнд хараахан таараагүй байсан юм. Сэлэнгийн савын хоёр хэсэг газар малтсан нийт монгол булшаас монгол эмэгтэйн богтаг малгай 2, ясан бэл 2, варду үсэг бүхий хөөмөл эд 3ш олдсон нь судалгааны ач холбогдол өндөртэй эх хэрэглэгдэхүүн болох нь эргэлзээгүй юм. Бургалдайн хөндийд малтсан 6 монгол булш бүгд идэр залуу насныхны оршуулга бөгөөд хүүхдийн 2 оршуулгыг эс тооцвол бүгд эмэгтэйчүүдийнх ажээ.

2005 оны 6-7-р саруудад доктор (Ph.D) З.Батсайханы удирдсан МУИС-ийн НШУС-ийн Антропологи-археологийн II ангийн оюутны хээрийн дадлага шинжилгээний анги Сэлэнгэ аймгийн нутагт эрт, дундад үеийн нүүдэлчдийн зарим булш малтан судалжээ. Тухайлбал, Ерөө сумын төвөөс урагш 9 км-т Карниковын ам хэмээх олон үеийн нүүдэлчдийн дурсгал бүхий Ерөө голын хойд дэнжид орших сөл сайтай газар 59 оршуулга илрүүлэн бүртгэснээс 5 булш малтан шинжилсэн байна (Батсайхан 2005). Эдгээр булшнууд нь хүннү 1, тодорхойгүй 2, монгол 2 байна.

Хүннү булш. (Малтлагын дугаар булш ¹ II-1).

Е 06°44'50,9" N 49° 40' 43,7" солбицолд уулын наран мандах энгэрт оршоосон хүннүгийн 4 булшны өмнөд этгээдэд байрлалтай. 680 см дундаж голчтой, дугаригдуу далантай бөгөөд зүүн хойд хэсэгтээ ихээхэн эвдэрсэн байна. 185 см гүнээс зүүн хойш азимутын 35° ын чигтэй, харьцангуй сайтар хадгалагдсан 300x110 см хэмжээтэй, 7 см зузаан банзаар хийсэн хашлага илрэв (Зураг 1). Хашлагын дотор зүүн хойд буланд эрүүний яс нь салж алга болсон эрэгтэй хүний гавалын ясыг хөсөр хаясан байхаас өөр зүйл алга ажээ.

Зураг 1. Хүннү булш. (Малтлагын дугаар булш ¹ II-1).



Банзан хашлагын зүүн хойд хэсэг алга болсон нь тонуулчин цооноглон энэ хэсгээр оршуулгад хүрч шарилыг суга татан гаргахад үрэгдэж үгүй болсон бололтой. Шарилыг тоноод ил хаяж орхисон ба түүний толгой нь тонуулчны цооногоор доош унасан байдалтай байна. Оршуулгын дотоод зохион байгуулалтын хувьд нэгэн сонирхол төрүүлэх зүйл нь

талигчийг авсанд бус, дөрвөн талаар нь зузаан банзаар хашлага хийж оршоосон явдал юм. Хүннү булшны оршуулгын зан үйлийг тусгайлан судалсан эрдэмтэд дотоод зохион байгуулалтаар нь хэд, хэдэн бүлэг болгон ангилснаас модон буюу дүнзэн хашлагатай, банзан австай гэсэн эл 2 ангилал хамгийн түгээмэл нь ажээ (Доржсүрэн 1961, Коновалов 1976, Цэвээндорж 1990, Давыдова 1996, Төрбат 2004). Бидний өгүүлэн буй оршуулга нь дээрх ангиллын аль нэгэнд хамаатуулан үзэж болмооргүй байгаа нь ховор зан үйлийн илэрхийлэл гэлтэй. Тухайлбал,

- Шарилыг банзан авсанд хийгээгүй байна. Авсны банзыг 4-5 см зузаантай болохыг судлаачид тэмдэглэсэн (Төрбат 2004: 45) хэдий ч энэхүү булшны дотоод байгууламжийн банз нь дунджаар 7 см зузаантай ажээ. Шал, таглаа хийсэн шинж байхгүй, хэмжээгээрээ хүннүгийн жирийн иргэдийн оршуулганы авснаас том зэрэг онцлон үзүүштэй шинжүүдээр нь бид тухайн байгууламжийг авс бус банзан хашлага гэж үзэж байна.

- Хүннүгийн жирийн иргэдийн булшны хашлагын тухай өгүүлэхэд ихэвчлэн шургаагаар 2-3 давхарлаж хийсэн, дотроо тусгайлсан банзан австай байдаг байна. Судлаач Ц.Төрбатын судалгаанд хамрагдсан хэрэглэгдэхүүнээс үзэхэд бидний өгүүлж буй банзан хашлагатай "...ганц булшинд ийм хэлбэрийн бололтой оршуулгын дотоод байгууламж тэмдэглэгдсэн" (Төрбат 2004: 44) бөгөөд түүнийг зохиогч оршуулгын мод ихэд ялзран муудаж дүнзэн хашлага, банзан авсыг ялгахад бэрх болдогтой холбон тайлжээ. Хашлаганд байх толгойн ясны байрлалаас харахад зүүн хойд зүгт хандуулсан оршуулга байсан нь илт байх аж. Хүн судлаач доктор Д.Түмэн гавалын ясны (краниологи) шинжилгээ хийж 30-35 насны эмэгтэй хүнийх гэж тодорхойлон МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхмийн "Олдворын бүртгэл"-ийн (цаашид "бүртгэл" гэх) 651 дугаарт бүртгэн авсан байна.

Монгол булш. (Малтлагын дугаар Булш ¹ I-1)

2005 ОНД СЭЛЭНГЭ АЙМГИЙН НУТАГТ АРХЕОЛОГИЙН СУДАЛГАА ХИЙСЭН ТУХАЙ

Уулын урд энгэрт $E 106^{\circ}44'14,3''$ $N 49^{\circ} 41' 05,9''$ солбицолд, уртраг дагуу сунасан байрлалтай, хөрснөөс ялимгүй цухуйсан хэсэг чулуун дараас байна. Ойр орчимд ийм зохион байгуулалт бүхий 10 булш байна. Хөрсөн дээрх чулуун өрлөгийг бүгдийг багтаасан 4x4 м харьцаатай талбайд цэвэрлэгээ хийхэд хойноос урагш сунаж дундуураа ихээхэн нумарсан чулуун өрлөг илрэв.



Зураг 2. Ерөө I-р булшны чулуун дараас

Тонуулчид ихээхэн сүйтгэсний улмаас дараас чулууны зохион байгуулалт эвдрэн нумарсан төрхтэй болжээ. 112 см гүнээс хүн, бог малын яс замбараагүй холилдсон оршуулга илрэв. Ясны байрлалаас тоймлон барагцаалахад умар зүгт хандуулан тавьсан бололтой оршуулга байна. Гавалын яс нь байхгүй ч эрүү нь үлдсэнээс харахад 50 эргэм насны хүний оршуулга аж. Д. Түмэн өмнө дурдсан бүртгэлийн ¹ 643-т данслан эрэгтэй, хижээл насны (mat) хүнийх гэж тодорхойлсон байна. Бодын хавирганы ясаар хийсэн жижигвэтэр бэл, нумын ясан наалтын нэгэн хос эд ангиас өөр эд өлгийн зүйлгүй болно. Цэргийн түүх судлаач Ж.Базарсүрэнгийн тайлбарлан нийтлүүлснээр энэхүү олдвор нь эвэр амгавч хэмээх наалтын нэгэн төрөл болох аж.



Зураг 3. Ясан бэл



Зураг 4. Нумын хос эвэр амгавч

Оньютой эвэр амгавч нь хожим монгол нумын үндсэн эд анги болон уламжлагдсан бөгөөд нумын дээд, доод чинадад байрлах ба хамрын хөвч тээглүүлэн торгох ухлаадсыг амгавчийн онь (Базарсүрэн 2006: 117) гэх ажээ.


Бэл нь эрт, дундад үеийн нүүдэлчдийн бүснээс зэр зэвсэг, ахуйн эдлэлийг агсахуйд нэн шаардлагатай хэрэглэл байсан бололтой. Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь”-д бэлийг “хэт хутга зэргийн юмыг зүүх оосрын чимэг” хэмээн өгүүлсэн

байдаг. Энэ нь нүүдэлчдийн бүсний хувьсал, хөгжлөөс хамааран өөрчлөгдсөөр бэл бэнчинг илтгэсэн эдийн нэг болжээ. Бидний өгүүлэн буй Карниковын амны монгол булшнаас олдсон энэхүү бэлийн бүсэнд сүвлэн тогтоох тууш ховил нь дөнгөж 1,2 см хэмжээтэй, бидний дор өгүүлэх Бургалдай голын хөндийд малтсан монгол булшнаас олдсон хонины шагайг босоогоор нь (морь, тэмээн талыг) нэвт нүхлэн хийсэн бэлийн ховил нь 1,5 см өндөртэй зэрэг нь дундад зууны монгол эрчүүдийн өдөр тутмын бүс шидмэс болон нарийн сураар хийгдсэн байж болох талтайг өгүүлж буй хэрэг билээ. Бүсний хэмжээ өргөсөх тусам бэлийн ховил мөн томсож чулуу, металл зэрэг бусад зүйлсээр урлах болсон нь Сүхбаатар аймгийн Онгон сумын нутгаас олдсон язгууртны булшны (Наваан нар, 2005) эх хэрэглэгдэхүүнээс тодорхой харагдаж байна. Эндээс номин шигтгээтэй, хаш бүсний зүүлт буюу бэл олдсон юм.

Хүннү булшинд бэл нэн ховор байдаг нь Эгийн голын бүлэг булшнаас зөвхөн 1 булшнаас бүсний зүүлт (Төрбат нар, 2003: 102) (магадгүй бэл байж болох талтай), Гол модноос цагаан хаш дуурайлган хийсэн шилэн бэл (Доржсүрэн 2003: 109-116) олдсоноос харагдаж байгаа юм. Түрэгийн нүүдэлчдийн оршуулга, хүн чулуудад бэлийг дагуулсан болон дүрсэлсэн зүйл ажиглагдахгүй байна.

Булш ¹ I- 2.

Е 106°44'15,8" N 49°41'05,4" солбицолд орших ба хөрсөн дээр хойноос урагш 300 см, баруунаас зүүн тийш 170 см сунаж тогтсон чулуун өрлөгтэй. 80 см гүнээс банзан австай, эмэгтэйн булш илэрсэн бөгөөд толгойн баруун талд нь богтаг малгай, зүүн талд нь 14 см урт үйлийн хайчийг үзүүрийг урагш харуулан тавьсан байна. Бүртгэлийн 644-т данслан 60-д насны (mat-sen) эмэгтэй хүнийх гэж Д.Түмэн тодорхойлжээ. Богтаг малгайн үйсэн дээр ямар нэгэн чимэглэл байхгүй бөгөөд даавуугаар доторлосон шинж мэдэгдэхгүй байна.



Зураг 5. Тодорхойгүй булш (Малтлагын дугаар Булш ¹ I-4).

Е 106°44'12,4" N 49°40'47,6" солбицолд Ерөө голын эргээс 5 м зайтай, дөрвөлжиндүү зохион байгуулалттай, баруун, зүүн талдаа жижгэвтэр дугуйрсан чулуун өрлөгтэй, түрэг булш маягийн өрлөг. Баруун талынх нь ¹ 3-р булш, зүүн талынх нь ¹ 5-р булш. 80 см гүнээс булшны

нүхний толбо илэрсэн бол харин баруун урд талын тусгайдуу чулуун өрлөг (булш ¹ 3) дороос ямар нэгэн нүхний толбо илрээгүй нь түүнийг дагалдах байгууламж болохыг илэрхийлж байгаа хэрэг бололтой.

Булшны нүхний хэмжээгээр малтахад 109 см гүнээс зулайн яс мэдэгдэж, азимутын 60° хазайлгаж баруун хойд зүг харуулан тавьсан авсгүй булш байна. Араг ясны урт 145 см бөгөөд аарцаг болон гавалын ясны байдлаас үзэхэд ахимаг насны эрэгтэй хүний оршуулга хэмээн урьдчилсан байдлаар дүгнэж байна. Д.Түмэн ¹ 645-т дугаарлан ахимаг (sen), эрэгтэй хүнийх болохыг тодорхойлжээ. Булшинд дагалдуулсан ямар нэг эд өлгийн зүйл эс олдov. Уг булш нь гадна зохион байгуулалт, байрлал зүйн хувьд түрэг булштай төстэй боловч он цагийг тоймлон тогтоож болох эд өлгийн зүйл эс олдov.

Булш ¹ I-5. E 106°44'12,7" N 49°40'47,6"

4-р булшны зүүн талд 180 см зайд орших бөгөөд хөрсөн дээр цөөн хэдэн чулуу мэдэгдэх төдий байгаагаас үзэхэд 4-р булшны нэгэн дагуул байгууламж гэж үзэж болохоор байлаа. 82 см гүнээс толгойг зүүн хойш азимутын 30°-т хандуулан тэнэгэр тавьсан 80 см урт хүүхдийн оршуулга илрэв. Цээж, хөл, баруун ташаа орчмоор үйс их



байгаагаас үзэхэд бүх биеийг ороож байсан бололтой. Хүүхдийн гавалын нүүрэн хэсэг цөмөрч алга болсон бөгөөд ясны хадгалалт маш муу байна. Толгойн хэсгээс том, жижиг 5 ш хуван зүүлт олдov. Бүгд зөв дугуй хэлбэртэй, тус бүрийг жигдхэн нүхэлсэн нь хооронд нь хэлхэж зүүлт болгож ашиглаж байсан бололтой.

Зураг 6. Хуван зүүлт

Баруунбүрэн сумын нутаг Бургалдайн голын хөндийд археологийн хайгуул, малталт хийсэн нь

Сумын төвөөс урагш 12 км-т Бургалдайн голын баруун дэнжид хөтлийн энгэрт нүүдэлчдийн булш, тахилга тайлгын байгууламж их ажээ. Энэ талбайг бид “Орхон” хэмээн ерөнхийлөн нэрлэж дотор нь байрлалаас хамааран 3 бүлэг болгон дурсгалуудыг бүртгэв (Хүснэгт 1). Энд бид 6 монгол булш болон 3 тахилын байгууламж малтсан юм. Тахилын байгууламжийн эхнийх нь дөрвөлжин нөгөө нь хүннү булшийг санагдуулам дугуйрсан өрлөгтэй байлаа. Тэдгээрийг 40 см гүн малтахад эх хөрсөндөө тулж ямар нэгэн оршуулгын болон ёслолын зан үйлийн шинж мэдэгдсэнгүй.

Хүснэгт 1. Бургалдайн хөндийн Орхон талбай дахь булшны байрлал

№	Байрлал	Тодорхойлолт	Хэсэг	Түүхэн үе
1	E 104°53'0,4" N 49°04'58,6"	Толгой талдаа хөшөөтэй, Орхон I –ийн 3 тай төстэй	Орхон III Булш ¹ I малтав	Монгол
2	E 104°53'0,2" N 49°04'57,3"	Дугуй чулуун өрлөгтэй	Орхон III	Хүннү
3	E 104°53'00,4" N 49°04'56,6"	4 талдаа босоо чулуун хөшөөтэй хиргисүүр	Орхон III	Түрүү нүүдэлчдийн
4	E 104°53'02,7" N 49°05'02,7"	4-р булшны хойд талд нь	Орхон II	Монгол
5	E 104°53'02,9" N 49°05'02,7"	4-р булшны баруун хойд талд нь	Орхон II	Монгол
6	E 104°53'03,7" N 49°05'02,3"	5-р булшны хойно 10 метрт	Орхон I	Монгол
7	E 104°53'03,9" N 49°05'02,1"	6,7-р булшны хойно 15 метрт, үүний хажууд зэрэгцээ 2 байна.	Орхон I	Монгол
8	E 104°53'04,3" N 49°05'01,7"	6,7-р булшны зүүн талд 5 метрт, үүнээс зүүн урагш дор тус бүр 5 м зайтай 3 булш байна	Орхон I	Монгол
9	E 104°53'04,7" N 49°05'01,8"	Эдгээр 3 ын хойд талд	Орхон I	Монгол
10	E 104°53'04,4" N 49°05'01,8"	6,7-р булшны зүүн талд 4-метрт	Орхон I	Монгол
11	E 104°53'03,7" N 49°05'02,3"	Голын баруун эргийн ойролцоо замын зүүн талын уулын энгэрт 6 хиргисүүр байна.	Орхон II	Хиргисүүр

Монгол булшнууд

Хүннү булш хэлбэрт өрлөгөөс зүүн урагш 30 -аад метр зайд жалганы хойд эргээр ижил зохион байгуулалттай, эгнүүлэн үйлдсэн 7 булш байна. Гадна зохион байгуулалтаараа адил бөгөөд бүгд нямбайлан нэг үе өрсөн чулуун дараастай. Хөрсөн дээр ялимгүй цухуйсан ганц нэг чулуу нь мэдэгдэх төдий байгаа нь эрж олоход нэлээд төвөг учруулах аж. Булшны чулуут дээш нь овоололгүй, зөвхөн өрж тавьсан нь монголын дундад үеийн оршуулгын нийтлэг зан үйлээс ихээхэн өөр ажээ.

Булш 13. E 104°53'03,3" N 49° 05'02,3" д.т.д 872 м

240 x 80 см харьцаатай нямбайлан өрсөн чулуун өрлөгийн зохион байгуулалт нь алдагдаагүйгээс уг булш тоногдоогүйг харж болохоор байлаа. 104 см гүнээс хойш нь харуулж тэнэгэр байдалтай тавьсан нимгэн банзан австай оршуулга илрэв. Ясны хадгалалт маш сайн бөгөөд гавалын яс заадсаараа салж, хавирга хугарсан байсан нь хөрсний даралтаас болсон бололтой. Хүн судлаач доктор Д.Түмэн бүртгэлийн¹ 650-дугаарт данслан идэр насны (adult), эмэгтэйн оршуулга болохыг тодруулжээ.

Авсны гадна талд нь хойд ирмэг түшүүлэн хонины шаант чөмөг босоогоор нь, толгойн зүүн талд нь будааны хэмжээний хэлхэж тогтоох зориулалт бүхий нэвт

нүхэлсэн сувсан чимэгтэй богтаг малгай тавьжээ. (Батсайхан нар, 2005) Малгайн доторлогоо болох нэхмэл эдлэлийн урласан хээ үйсэн дээр тод үлдсэн байна (Зураг 7).



Зураг 7. Малгайн дотор үлдсэн хээ

4 см голчтой дугуй нимгэн зэс хөөмөл эдлэл баруун бугалга орчмоос олджээ. Түүний гадна хүрээгээр тойруулан бяцхан товруунуудыг урласан бөгөөд голд нь кирилл цагаан толгойн Ы хэлбэрийн ланз

үсэг байж болох дүрсийг товойлгожээ. Гурван хэсэг болон хугарсан байна. Уг эдлэл нь хувцасны чимэг, тээг бололтой бөгөөд бурхны шашны утгыг хараахан илэрхийлээгүй мэт. Нарийвчлан судлах нэн шаардлагатай байна. Ийм дүрс бүхий эдлэл урьд өмнө дундад үеийн монгол оршуулгаас олдож байжээ. Тухайлбал, 2005 онд малтсан Сүхбаатар аймгийн нутаг Таван толгой (Наваан нар, 2005) -н монгол язгууртны булшинд дагалдуулсан хүрэл толь дээр дүрсэлсэнтэй адил бөгөөд түүнийг бурханч лам Г.Пүрэвбат “ОМ” гэсэн утгатай энэтхэгийн варду үсэг хэмээн тайлсан (Баттөмөр, 2005) байна.

Булш¹ 4. E 104°53'02,8" N 49°05'02,6" д.т.д 875м

3-р булшнаас зүүн хойш 10 м зайд оршино. Азимутын 45° хазайлттай, хойноос урагш 260 см, өргөрөг дагуу хамгийн өргөн хэсэгтээ 180 см хүртэл сунасан. 3-р булшны адил нямбай чулуун өрлөгтэй бөгөөд 100 см гүнд талийгчийг тавьжээ. Араг ясны урт 153 см. 3-р булшны адил хөндөгдөөгүй ажээ. Бүртгэлийн¹ 651-т данслан 30-35 насны эмэгтэйн хүний яс болохыг урт ясны (остелогии) судалгаагаар доктор Д.Түмэн тогтоожээ. Баруун сүүжний толгой дээр 3-р булшны олдворын адил хэмжээтэй дугуй зэс хөөмөл эдлэл тавьжээ. Энэхүү олдвор нь бүтэн бөгөөд ар талдаа хүний хурууны хэмжээний хөндий хоолой бүхий тогтоогчтой аж (Зураг¹7). Уг эдлэлийн хүрээ нь 3-р булшны олдворын адил хөөмөл товруу бус харин цэцгийн дэлбээ мэт хээгээр хүрээлүүлж доторхи үсэг нь адил юм. Тогтоогч хоолойг нэвт нүхэлсэн сүвэнд нарийн сурны өөдөс байна. Эндээс дүгнэхэд уг эдлэлийг бүсний нэгэн төрлийн чимэг гэж үзүүштэй юм. Хонины шаант болон өөр ямар нэг эд өлгийн зүйл эс олдов.

Булш¹ 5. E 104°53'03,5" N 49°05'02,1" д.т.д 872м

3-р булшнаас зүүн урагш 10 м зайнд уртраг дагуу 280 см, өргөрөг дагуух хамгийн өргөн нь 160 см чулуун өрлөг. Зүүн хойш азимутын 45° хазайлттай байна. Өмнөх булшны адил зохион байгуулалттай. 104 см гүнээс нарийн банзан австай толгойг ялимгүй баруун тийш хазайлгасан оршуулга илрэв. Авсны гадна толгой талд

шаант чөмөг босоогоор нь тавьжээ. Дунд чөмөгний доороос өмнөх хоёртой ижил дүрс бүхий ногоон зэс хөөмөл товруу олдов. Авсны урт 170 см, араг ясны урт 140 см аж. 20-30 (adult) насны эмэгтэй хүний яс гэж тодорхойлон бүртгэлийн 652-т дансалжээ.




Зураг 8. Үл мэдэгдэх үсэгтэй зэс хөөмөл

Булш ¹ 6. E 104°53'03,8" N 49°05'01,8" д.т.д 873м

7-р булшны хамт хосоор нь тавьсан учраас хамтад нь цэвэрлэж малтав. 6-р булш нь хөрсөн дээр уртраг дагуу 200 см, өргөрөг дагуу 170 см сунасан байна. Гар зурган дээр зүүн гар талд нь харагдах хэмжээгээр том өрлөгтэй байгууламж нь юм. 120 см гүнээс үйсэн тагтай, 145 см урт, дээд хэсгээр өргөн нь 59 см, доогуураа 45 см өргөнтэй банзан авс илрэв. Мөн л зүүн хойш чигтэй хандуулсан байлаа. Хадгалалт муугаас болон хүүхдийн ясны хэврэгшлээс хамааран толгойн яс нь бяцарч бусад ясны зохион байгуулалт алдагджээ. Ямар нэгэн эд өлгийн зүйл олдсонгүй. 10-аад насны хүүхдийн оршуулга байна.

Булш ¹ 7. E 104°53'04,0" N 49°05'01,8" Хойноос урагш 200 см, баруунаас зүүн тийш 150 см харьцаатай чулуун дараас бүхий булш. 108 см гүнд 80 см урт, 30 см өргөн




үйсээр хучсан модон австай нялх хүүхдийн булш илрэв. Авсыг задлан үзэхэд зохион байгуулалт алдагдаагүй нялх хүүхдийн яснаас өөр зүйл эс олдов. Эдгээрийг ¹ 653, 654-т тус тус бүртгэн авсан байна.

Зураг 9. 6,7-р булшны оршуулга

Талбай: Орхон II

Булш 1. E 104°53'23,6" N 49°50'00,2" д.т.д 845м



Зураг 10. Тахилын байгууламж

Энэ талбайд дунд зэрэг хэмжээ бүхий 11 хиргисүүр байх бөгөөд урд талын зэрэгцээ 3 хиргисүүрийн дөрвөлжин чулуун хүрэнээс хойш 8,5 м зайнд орших дугуйрсан монгол булш маягийн өрлөг. Энэ нь нэг талаас хиргисүүрийн дагалдах байгууламжуудын нэг нь байж болох мэт боловч нөгөө талаар хожмын монголчууд олон хиргисүүрийн дунд

хүнээ оршуулсан байж болох тул малтав (зураг¹10). Чулуун өрөөсийг хуулан 4 х 4 м талбайд 50 см хүртэл малтаж үзэхэд булшны нүх илрээгүй төдийгүй адуу, малын ямар нэг яс мэдэгдсэнгүй.

Талбай : Орхон III

Булш 1. E 104°53'03,6" N 49°04'58,7" д.т.д 868м

Орхон I талбайгаас урагш жалганы өмнө талд бусдаас онцгойдуу чулуу босгож хийсэн хөшөөтэй монгол булш юм. Зүүн хойш азимутын 20° хазайлттай хойноос урагш сунасан байрлалтай. Орхон I талбайн монгол булшнуудын адил чулуун өрлөгтэй, нэг үе нямбайлан өрсөн дараастай (Зураг 11) байна. 83 см гүнээс гавалын яс илэрсэн бөгөөд толгойн чанх дээр 75 см өндөртэй, хөрсөн дээр 25 см ил гарсан хөшөөг байрлуулжээ.



Зураг 11. III-ын I булшны чулуун өрлөг

Нимгэн банзан австай, сайн хадгалагдсан, эхний тавилтаараа буй оршуулга байна. Хүн судлаач Д.Түмэн оршуулгын араг ясанд шинжилгээ хийж өсвөр насны (Juv) эмэгтэй хүүхдийн булш гэж тодорхойлон бүртгэлийн ¹ 655-т тэмдэглэн авчээ. Толгойн баруун талд хонины шагайт

чөмөг, далны ясыг тавьжээ. Баруун сүүжний дороос жижиг төмөр дэгээ гарсан нь бүсний тоног хэрэгсэл бололтой. Ясыг хураан авч цэвэрлэх явцад бэлхүүсийн орчим

дороос хонины шагайгаар хийсэн бэл олдов. Түүнийг маш нарийн урласан нь шагайг босоогоор нь гонзгой хэлбэртэй тууш нүхэлж үзүүр хэсэгт нь хөндлөн дугуй нүхэлсэнээс харагдаж байна. Тууш нүхээр нь бүсэнд хийж дороос нь ямар нэг зүйл зүүж ашигладаг байсан бололтой юм.

НОМ ЗҮЙ

- Базарсүрэн Ж.*, 2006. Чингис хааны цэргийн зэр зэвсэг. УБ.
Батсайхан З., 2002. Хүннү (Археологи, угсаатны зүй, түүх). УБ.
Батсайхан З., Өлзийбаяр С. 2005. 2005 оны хээрийн шинжилгээний ажлын тайлан (МУИС-ийн археологийн II анги). МУИС Археологи, антропологийн тэнхим, УБ.
Баттөмөр Л., 2005. Онгон таван толгойн онцгой нэгэн дурсгал (илтгэл). МУИС оюутны ЭШБХ УБ.
Давыдова А.В., 1996. Иволгинский археологический комплекс. Археологические памятники сунну. Вып.2, СПб.
Доржсүрэн Ц., 1961. Умард Хүннү. УБ.
Доржсүрэн Ц., 2003. 1956-1957 онуудад Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн нь. Археологийн судалгаа эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл. УБ.
Коновалов П.Б., 1976. Хунну в Забайкалье (погребальные памятники). Улан-Удэ.
Наваан Д., Эрдэнэ М., 2005. 2005 оны археологийн хээрийн шинжилгээний тайлан. МУИС, Археологи-Антропологийн тэнхим. УБ.
Төрбат Ц., Амартүвшин Ч., Эрдэнэбат У., 2003. Эгийн голын сав дахь археологийн дурсгалууд. УБ.
Төрбат Ц., 2004. - Хүннүгийн жирийн иргэдийн булш. УБ.
Цэвэл Я. 1963 Монгол хэлний товч тайлбар толь УБ.
Цэвээндорж Д., 1990. Худгийн толгой, Солби уул, Наймаа толгойн Хүннү булш. Түүхийн судлал. УБ.

SUMMARY

Z.Batsaikhan, S.Ulziibayar

ARCHAEOLOGICAL EXCAVATIONS CARRIED OUT IN THE TERRITORY OF SELENGE AIMAG (2005)

Large cemetery with tens of graves of ancient nomads was found at Karnikov valley, Yuroo soum and Burgaldai valley, Baroonburen soum of Selenge province. One grave from Xiongnu, and eight graves from Mongolian period were excavated. During the excavation various archaeological findings, such as copper decoration with engraving, "bogtag" hat decoration, decorative cord made of bone to hang from the belt were unearthed. Copper decoration with engraving of Tibetan letters found from the Mongolian period grave may indicate the spread of Buddhist religion at that time.